

Гэрээ болон ёслолуудаар дамжуулан Аврагчтай холбогдох нь



БҮС, ЗОХИЦУУЛАХ, НОМЛОЛ, ГАДАС, ТОЙРОГ БОЛОН САЛБАРЫН ЗӨВЛӨЛҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ТОЙМ

Энэхүү зааварчилгааны үеэр та гэрээ болон ёслолуудаар дамжуулан Аврагчтай холбогдох замынхаа өөр өөр хэсэгт буй Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн туршилагыг харж мөн сонсох болно. Хайрлах, хуваалцах, урих нь тэднийг гэрээний зам дээр баяр хөөртэйгөөр өсч хөгжихөд нь хэрхэн тусалсан тухай та сонсох болно. Та сургаал, ариун сүм, гэр бүлийн түүхийн ажлын талаар хуваалцах, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах зэрэг нь хэрхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг харж болно. Гэвч энэ бүхнээс илүүтэйгээр та эдгээр бүх зүйлс хэрхэн “Христ дотор нэгтгэгдсэн” (Ефес 1:10) байгааг олж харж болно.

АМЬДРАЛЫН ЭХЭН ҮЕ: ХҮҮХДҮҮД

Ерөнхийлөгч Жой Д.Жөүнс, хүүхдүүдтэй хийсэн бичлэгийг үзээд хүүхдүүдийг гэрээний зам дээр өөрсдийгөө Аврагчтай холбоход нь туслахын тулд юу хийх талаараа ярилц.

- Энэхүү бичлэгийг үзэж байхад Сүнс бидэнд юу заасан бэ?
- Хүүхдүүдийг сургаалыг хуваалцахаар чармайх үед хайрлах, хуваалцах, урих зарчмууд тэдэнд хэрхэн тусалдаг вэ?
- Баптисм хүртсэний дараа гэрээний зам дээр үлдэхэд нь хүүхдүүдэд үйлчлэл хэрхэн тусалдаг вэ?



АМЬДРАЛЫН ХОЁР ДАХЬ ҮЕ: ӨСВӨР ҮЕИЙНХЭН

Ерөнхийлөгч Бонни Х.Кордон, Ерөнхийлөгч Стэфэн Ж.Ланд болон өсвөр үеийнхэнтэй хийсэн бичлэгийг үзээд өсвөр үеийнхнийг гэрээний зам дээр өөрсдийгөө Аврагчтай холбоход нь туслахын тулд юуг явж мөн биелүүлэх талаараа ярилц.

- Бид өсвөр үеийнхнийг баптисмын гэрээгээ сахиж, гэрээний зам дагуу дараагийн алхмаа хийхэд бэлтгэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?
- Хайрлах, хуваалцах, урих зарчмууд өсвөр үеийнхнийг ариун сүм, гэр бүлийн түүхийн ажилд оролцоход нь хэрхэн тусалдаг вэ?
- Бид өсвөр үеийнхнийг Аврагчтай холбоотой болж эхлэх үед нь найдвар болон хамаарлын мэдрэмжийг мэдрэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?

АМЬДРАЛЫН ГУРАВ ДАХЬ ҮЕ: ЗАЛУУЧУУД

Ерөнхийлөгч Марк Л.Пэйс болон залуучуудтай хийсэн бичлэгийг үзээд залуучуудыг гэрээний зам дээр өөрсдийгөө Аврагчтай холбоход нь туслахын тулд юуг явж мөн биелүүлэх талаараа ярилц.

- Бусдын бидэнд санал болгодог хайрлаж, хуваалцаж, урьдаг байдлаас бид юу сурч болох вэ?
- Залуучууд бие даасан байдлаа нэмэгдүүлж, бусдад үйлчилснээр найдвар болон дотно нөхөрлөлийг мэдрэхэд нь бид тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Тэднийг Их Эзэний Сүмд хэрэгтэй гэдгээ мэдэхэд нь бид тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Залуучуудыг Аврагчтай холбоход Сүмийн үр дүнтэй үйл ажиллагаа, анхаарал, халамжтай удирдагчид ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

АМЬДРАЛЫН ДӨРӨВ ДЭХ ҮЕ: НАСАНД ХҮРЭГЧИД

Ерөнхийлөгч Жийн Б.Бингам болон насанд хүрэгчидтэй хийсэн бичлэгийг үзээд насанд хүрэгчдийг гэрээний зам дээр өөрсдийгөө Аврагчтай холбоход нь туслахын тулд юуг явж мөн биелүүлэх талаараа ярилц.

- Гэрээнүүд хэрхэн бидэнд хүнд хэцүү цаг үед ч эдгээлийг авчирч, зам дээрээ үлдэхэд маань тусалдаг вэ?
- Гэрээнүүд болон ёслолуудаар дамжуулан гишүүд өөрсдийгөө болон бусдыг Аврагчтай холбоход нь тусалж чадах ямар арга замуудыг бид олж мэдсэн бэ?
- Сүнслэг байдлаараа бие даасан байдлаа хөгжүүлэх нь бидэнд хайрлаж, хуваалцаж, урихад хэрхэн тусалдаг вэ?

БҮС, ЗОХИЦУУЛАХ, НОМЛОЛ, ГАДАС, ТОЙРОГ, САЛБАРЫН ЗӨВЛӨЛҮҮДЭД ЗОРИУЛСАН ЭХ СУРВАЛЖ

Хүүхэд болон өсвөр үеийнхэнд

ХҮҮХЭД БОЛОН ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ТАЛААРХ ТОЙМ

Хүүхэд, өсвөр үеийнхний хөтөлбөр нь өсөн өндийж буй үеийнхний Есүс Христэд итгэх итгэлийг хүчирхэгжүүлж, хүүхэд, өсвөр үеийнхэн болон тэдний гэр бүлд амьдралын сорилт бэрхшээлүүдтэй тулгарах үед гэрээний замаар урагилахад туслах зорилготой юм. Уг хөтөлбөр хүүхэд, өсвөр үеийнхнийг өдөр тутмын амьдралдаа Израилын цугларалт, авралын болон өргөмжлөлийн ажилд оролцох хичээл зүтгэлд нь тусалдаг. Энэ нь гэр бүл төвтэй, сүмээр дэмжигддэг хөтөлбөр юм.



ӨСӨН ӨНДИЙЖ БУЙ ҮЕИЙНХНИЙ НАЙДВАР

Хүүхэд, өсвөр үеийнхэн нь өсөн өндийж буй үеийнхэнд илчлэлт, сонгох эрх, харилцаа зэрэг олон арга замуудаар дамжуулан өсөж хөгжихөд нь тусалдаг. Хувь хүмүүс өөрсдийнхөө төлөө сонгох эрхээ ашиглан өсөж хөгжих боломжуудыг сонгох үедээ хувийн илчлэлт хүлээн авч үүнийхээ дагуу үйлдэхэд суралцдаг. Энэ нь мөн өсвөр үеийнхэнд чуулга болон анги удирдахад суралцах үед нь тохиодог. Тэд хамтран ажиллаж, хамтдаа үйлчлэх үедээ гэр бүл, удирдагч, үе тэнгийнхэнтэйгээ харилцаа тогтоож тэд хамааралтай бөгөөд Их Эзэний ажилд хэрэгтэй гэдгээ мэдэж авах болно.

ӨНӨӨДӨР БИД ХААНААС ЭХЛЭХ ЁСТОЙ ВЭ?

Бид хүүхэд, өсвөр үеийнхэн, тэдний эцэг эх, удирдагч нарыг Аврагчийн ажилд оролцсоноор Түүнтэй илүү адил болох амлалт өгөх эсвэл дахин амлахад урьж байна. Эдгээр хүчин чармайлт нь хэцүү байх шаардлагагүй! Дараах энгийн арга замуудаар эхэлж болно. Үүнд:

Эцэг эхчүүд

- Сургаалаас суралцахаар гэр бүлээрээ цуглар. *Ирээд, Намайг дага* гарын авлагын эх сурвалжууд тусалж чадна. Та гэрээнүүд, илчлэлт, сонгох эрх, патриархын адислалууд гэх мэт сэдвүүдийн талаар ярилцаж болно.
- Гэр бүлийн үйл ажиллагаа төлөвлө. Та хөрш эсвэл хамт олныхоо хэн нэгэнд хэрхэн аюулгүйгээр үйлчилж болох вэ? JustServe боломжтой газруудад энэ нь танд санаа олоход туслах болно.
- Охид хөвгүүд бүртэй хувьчлан уулз. Тэдний хүсэл сонирхол болон хэрхэн өсөж хөгжихийг хүсэж байгаа талаар нь ярилц. Тэдний хувийн өсөлт хөгжлийг дэмжиж тусал. Тэдний тавьсан зорилго болон юун дээр ажиллахыг хүсэж байгаа талаар нь ярилц.

Хүүхдийн хэсгийн удирдагчид

- Хүүхдүүдийн гэр орны нөхцөл байдлын талаар мэдэж аван хувь хүнийх нь хувьд тэдэнд туслахын тулд илчлэлт эрэлхийл.
- Ням гаргийн цуглаан болон Хүүхдийн хэсгийн үйл ажиллагаануудыг биечлэн эсвэл алсын зайнаас (аюулгүй болон зөвшөөрөгдсөн үед) хийж эхэл.
- Хувь хүмүүсийн зорилгыг үйл ажиллагаатай холбох талаар бүү санаа зов! Таны анхаарал хүүхдүүд, тэдний гэр бүлтэй ялангуяа тэдэнд тусламж хэрэгтэй эсвэл туслалцаа хүссэн үед нь холбоо тогтоож, тэднийг адислахад төвлөрөх явдал юм.

Өсвөр үеийнхний насанд хүрсэн удирдагчид

- Ням гаргийн цуглаан, чуулга болон ангийн үйл ажиллагаануудыг биечлэн эсвэл алсын зайнаас (аюулгүй болон зөвшөөрөгдсөн үед) хийж эхэл. Өсвөр үеийнхнийг Залуу эмэгтэйчүүд болон Аароны санваарын чуулгын уриаг цээжилж, уриагаа уншиж, уулзалтуудаа эхлэхийг уриал.
- Чуулга болон ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийг дуудаж, онцгойлон адисалж, хүчирхэгжүүл. Тэдэнд ерөнхийлөгчийн зөвлөлийн уулзалтыг тогтмол хийж, Ням гаргийн уулзалтууд болон үйл ажиллагаануудыг төлөвлөж удирдахад нь тусал. Тойргийн өсвөр үеийнхний зөвлөлийн хурлыг хийж номлолын ажил, ариун сүм болон гэр бүлийн түүхийн зохицуулалтын уулзалтуудад оролцоход уриал. Шаардлагатай үед ерөнхийлөгчийн зөвлөлийг орлолгүйгээр зааварчилж дэмж. Ерөнхийлөгчийн зөвлөлүүдийг удирдах арга барилд суралцахдаа **чуулга болон ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн эх сурвалжуудыг ашиглахад нь тусал.**
- Аюулгүй байдлын удирдамжийн дагуу өсвөр үеийнхний зугаалга болон чуулганыг 2021 онд төлөвлөж, зохион байгуул.
- Хувь хүмүүсийн зорилгыг үйл ажиллагаатай холбох талаар бүү санаа зов! Эрч хүчээ өсвөр үеийнхэнтэй холбоо тогтооход зориул. Мөн та чуулга болон ангийн ерөнхийлөгчийн зөвлөлд үйл ажиллагаануудыг өсвөр үеийнхний хэрэгцээтэй холбоход нь тусалж болно.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙГ CHILDRENANDYOUTH.CHURCHOFJESUSCHRIST.ORG-ООС ҮЗНЭ ҮҮ.

Насанд хүрэгчдэд

ГБЗ-ЫН ЦУГЛАРАХ ГАЗАР

Тэргүүн Зөвлөлөөс бүсийн хэрэгцээнд тулгуурлан ганц бие залуучуудад зориулсан цугларах газруудыг бий болгох зөвшөөрөл өгсөн. Цугларах газар нь одоо байгаа байгууламжид (цуглааны байр эсвэл институтийн байр гэх мэт) ганц бие залуучууд найзуудын хамтаар дараах зүйлсийн заримд эсвэл бүгдэд нь (орон нутгийн хэрэгцээ болон боломжид тулгуурлан) оролцохоор цугларч болох тусгай байршил юм. Үүнд:

- Шашны боловсрол болон сургаалыг суралцах (институтийг оролцуулан)
- Үйлчлэл болон нийгмийн үйл ажиллагаа
- Ариун сүм, гэр бүлийн түүхийн үйл ажиллагаа
- Бие даах чадвар болон боловсролын боломж
- Номлогчийн болон нийтийг хамарсан үйл ажиллагаа
- Сүмийн бусад хөтөлбөрүүд



Бүх цугларах газруудыг Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөл баталж, гадасны ерөнхийлөгч, бишопууд хянах ёстой.

ГАНЦ БИЕ ЗАЛУУЧУУД БА ГАНЦ БИЕ НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН ДУУДЛАГУУД

Саяхны бодлогын өөрчлөлт, тодруулга нь ганц бие гишүүдийн Их Эзэний Сүмд үйлчлэх боломжийн хязгаарлалтын тухай үл ойлголцол, хуурамч уламжлалыг шийдвэрлэжээ. Тэргүүн Зөвлөл, Арван хоёрын чуулгаас баталж *Ерөнхий гарын авлага*-д тусгасан эдгээр бодлогын өөрчлөлт, тодруулга нь ганц бие залуучууд болон ганц бие насанд хүрэгчид гадас, тойргийн удирдагч зэрэг олон дуудлагаар дамжуулан өөрсдөө адислагдаад зогсохгүй бусдыг мөн адислах боломжтой гэдгийг тайлбарладаг. Үүнтэй ижил бодлогууд одоо сүмийн бүх нэгжүүдэд, түүний дотор ганц бие залуучууд, ганц бие насанд хүрэгчдийн нэгжүүдэд хэрэгжиж байна. Ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөл, гадасны халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөлд ганц бие залуучууд, ганц бие насанд хүрэгчдийн үйлчлэлийн эсрэг байсан хязгаарлалтыг хассан.

Ганц бие гишүүд тойрог, гадасны байгууллагын ерөнхийлөгчийн зөвлөл, ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөл, дээд зөвлөл болон гадасны ерөнхийлөгчийн зөвлөл зэрэг удирдах албанд үйлчилж болно.

Бидэнд хүн бүгд хэрэгтэй бөгөөд тэднийг угтан ав, хайрла, хуваалц, урь

Гишүүд дотно нөхөрлөлийг мэдрэх гэж ядаж байхад нь заримдаа удирдагчид болон бусад хүмүүс санамсаргүйгээр тэдэнд энд орон зай байхгүй эсвэл тэдний хэрэг байхгүй гэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлсэн зүйлсийг хэлдэг.

Хайрлах, хуваалцах, урихтай холбоотой эдгээр үнэнийг санаж байх нь Есүс Христийн сүм дэх үйл ажиллагаа, нөхөрлөл, хүрээлэлд бүгдийг хүлээж авахад туслах болно.

- Хүн бүр тэнгэрлэг чанар хийгээд хувь заяатай Бурханы хайртай хүүхдүүд билээ. Түүний итгэлтэй тэдэнд амласан мөнхийн адислалуудаас гадна Тэрээр Өөрийн хүүхдүүдийг энэ амьдралын турш, одоо ч адислахыг хүсдэг.
- Бурханы хүүхэд бүр Түүний хаант улсыг байгуулах ажилд хэрэгтэй.
- Хэн нэгэнд тэрээр бидний нэг хэсэг бас бидэнд хэрэгтэй гэдгийг мэдрэхэд нь туслахын тулд хайраар эхэл. Тэр хүмүүсийн туршлагыг ойлгохын тулд сонс. Та аль хэдийн мэддэг эсвэл ойлгодог гэж бүү бод.
- Бидний болон бусдын амьдралд тулгардаг бүх асуултуудын хариулт бидэнд байхгүй. Жишээлбэл: Бид хүн яагаад тодорхой нэг сорилт бэрхшээлтэй тулгардаг шалтгааныг мэдэхгүй.
- Нээлттэй байж аливаад шүүмжлэлгүй ханд. Тухайн хүн аяллынхаа хаана ч байсан гэсэн хүн бүрийг угтаж ав. Туслахыг санал болгож, Сүмд хүн бүр хэрэгтэй гэсэн үнэн дээр төвлөр.
- Хэрэв та санамсаргүйгээр гомдмоор зүйл хэлбэл өөрийгөө өмөөрөх хэрэггүй. Уучлал гуйгаад өршөөл эрж, өөрийгөө сайжруул.



ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД БУЙ ГИШҮҮДЭД ТУСЛАХ ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙГ COUNSELINGRESOURCES.CHURCHOFJESUSCHRIST.ORG-ООС ҮЗНЭ ҮҮ.

ТУСТАЙ ҮГС

- **Тавтай морилно уу! Та бидэнд хэрэгтэй бас бид танд хайртай. Энд байгаад тань баярлалаа.**
- **Өөрийн туршлагаас зааж өгөөч. Та намайг юуг ойлгоосой гэж хүсэж байна вэ?**
- **Та аяллынхаа хаана ч байлаа гэсэн та бидэнд хэрэгтэй. Бид таныг урьж байна. Бид хэрхэн тусалж чадах вэ? Та бидэнд хэрхэн тусалж чадах вэ?**
- **Бурхан таныг одоо аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Түүний сайн мэдээ Түүний бүх хүүхдүүдийг найдвар, аз жаргалаар хангадаг.**



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ